



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 5/71

Хэрлэн сум

Б.Дархантөрийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.10, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.6, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Улсын Их Хурлын 1995 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам", Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2 дугаар хавсралтын 2 дахь заалт, 2007 оны "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" 354 дүгээр тогтоолын 1 дүгээр, 2014 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Батжаргалын Дархантөрийг 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Н.Ган-Адъяа	-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	З.Буянцэцэг	-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

2//.

3. Б.Дархантөрийн үндсэн цалинг ТЗ-9-5 шатлалаар 864211 /найман зуун жаран дөрвөн мянга хоёр зуун арван нэгэн/ төгрөгөөр, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10, зэрэг дэвийн нэмэгдлийг 15 хувиар тооцож олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын нягтлан бодогч /Л.Түмэнжаргал/-д зөвшөөрсүгэй.

4. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Дархантөрд үүрэг болгосугай.

5. Б.Дархантөрд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА